

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-7

1. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./ 4-7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 22-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 36 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Батшугар, Ц.Мөнхбат, С.Цэнгүүн;
Чөлөөтэй: Ч.Анар.

**Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын
хороонд хүргүүлнэ./**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн яамны Инновацын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Мөнхбат, Харилцаа холбооны бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баясгалан, Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Пүрэвням, Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн дарга Д.Батбаяр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, И-Монгол Академи УТҮГ-ын Цахим засаглалын хэлтсийн дарга Х.Энхманлай, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Орлогын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Зарлагын хэлтсийн дарга Л.Ичинноров, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Тогтоолын төслийн нэгдүгээр хавсралтын талаар:

Ж.Золжаргал: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 4.5.6 дахь заалт нэмэх:

“4.5.6.Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	2
Бүгд:	7

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Номингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр “хуралдааны тэмдэглэлд” тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 7 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хоёрдугаар хавсралтын талаар:

Ж.Золжаргал: 2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Номингийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 2.15 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.15.1.5 дахь төсөл, арга хэмжээ нэмэх:

“Бодлогын үндэслэл”-д “Алсын хараа-1.2.5, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр-3.3.6.14” гэж, “Төсөл арга хэмжээ”-нд “2.15.1.5.“Цахим соёл-II” арга хэмжээг хэрэгжүүлэх CREATIVHUB, GLAM-Галерей, номын сан, архив, музейн дундын цахим систем/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгжид”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “5” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Нийт санхүүжилтийн дүн”-д “3,000,000.00” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт”-д “1,000,000,00” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин, Б.Пунсалмаа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр “хуралдааны тэмдэглэлд” тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 7 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 12 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 36 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ингээд хуралдааны ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, Ж.Золжаргал, Т.Мөнхсайхан, Ч.Номин, Б.Пунсалмаа, Ч.Ундрам нар Байнгын хорооны хуралдаанд оролцож, 63.6 хувийн ирцтэй байна. Ирц танилцуулж дууслаа.

Одоо хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ гаргаад Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 1. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тогтоолын төслийг тараасан байгаа. Ажлын хэсгийн хуралдаанд оролцогчдын нэрсийг танилцуулъя.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од, Инновацын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Мөнхбат, Харилцаа холбооны бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баясгалан, Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Пүрэвням, Цахим шилжилтийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн дарга Д.Батбаяр, Стратеги бодлого төлөвлөлтийн газрын Цахим хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч Ч.Болор-Эрдэнэ И-Монгол Академийн Цахим засаглалын хэлтсийн дарга Х.Энхманлай, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Үндэсний дата төвийн захирал М.Баттулга, Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, ингээд Сангийн яамнаас Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Отгонцэцэг, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Ингээд “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Асуудалтай холбоотой асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Асуулт байхгүй байна.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан 1 болон 2 дугаар хавсралтад Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулъя.

Энэ Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй 2 санал, 3 санал байна. 2 зарчмын зөрүүтэй санал, найруулгатай холбоотой 1 санал. Энэ уншиж танилцуулъя.

1.Тогтоолын төслийн нэгдүгээр хавсралтын талаар:

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 4.5.6 дахь заалт нэмэх:

“4.5.6.Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэнэ.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Баярмаа гишүүн ирээгүй тээ? Асуулт тус тусад нь байна шүү дээ. 2 дугаар саналыг нь хүлээх юм уу яах вэ? Эхний саналтай, энэ саналтай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна. Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Ингээд тогтоолын төслийн томъёоллоор санал хураая.

Төслийн 1 дүгээр хавсралтын 4.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 4.5.6 дахь заалт нэмэх:

“4.5.6.Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэнэ.” гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

71.4 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Номин протоколоор дэмжсэнээр бүртгэж авна уу. Төхөөрөмж ажиллаагүй учраас. 2 дахь саналыг танилцуулъя.

Төслийн 2 дугаар хавсралтын 2.15 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.15.1.5 дахь төсөл, арга хэмжээ нэмэх:

“Бодлогын үндэслэл”-д “Алсын хараа-1.2.5, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр-3.3.6.14” гэж, “Төсөл арга хэмжээ”-нд “2.15.1.5. “Цахим соёл-II” арга хэмжээг хэрэгжүүлэх CREATIVHUB, GLAM-Галерей, номын сан, архив, музейн дундын цахим систем/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгжид”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “5” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Нийт санхүүжилтийн дүн”-д 3 сая, мянган төгрөг юм уу? “3,000,000.00” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт”-д “1,000,000,00” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин.

Энэ саналтай холбоотой асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт байхгүй байна.

Саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саналын томъёолол.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал.

Найруулга дээр бага хэмжээний засварууд орох шаардлагатай байж болно гэсэн үндэслэлийг багийн ажлын албаны зүгээс ярилцаад гаргасан байгаа. Тийм болохоор агуулгыг нь өөрчлөхгүйгээр найруулга дээр оруулна гэсэн ийм санал байна.

Асуулттай гишүүд байна уу?

Байхгүй байна.

Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Номин болон Пунсалмаа нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Санал 57.1 хувиар дэмжигдлээ.

Ингээд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас бас нэмэлт, саналуудын төслийг мэдээлэл бол ирүүлсэн байгаа.

Тэгэхдээ Дэгийн тухай хуулийн дагуу 2 хоногийн өмнө мэдээлэл авна гээд ажлын албанаас 5 сарын 20-ны 17:30 хүртэл авсан байна. Тэгэхээр одоо томьёолол бэлэн болоогүй байгаа учраас та бүхэн ажлын хэсгийнхээ хүрээнд энэ асуудлаа ярьж танилцуулахыг хүсэж байна.

Тэгээд шаардлагатай бол төсвийн хэлэлцэх үеэр бас оруулж ирэх боломжтой гэж бодож байна. Ингээд өнөөдрийн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт дууслаа.

Тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар уншиж танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

10.48 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР